



## УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 1/29

Улаанбаатар хот

### Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам батлах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчийн” тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Музейн өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга /Г.Очбаяр /-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



С. ЦАЦРАЛТ



**УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН  
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙНЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Улаанбаатар хотын музейн Өмч хамгаалах байнгын зөвлөл /цаашид Зөвлөл гэнэ/-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

**Хоёр. Өмч хамгаалах байнгын зөвлөл**

2.1. Зөвлөл нь байгууллагын үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг эзэмших, зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэхэд эрх зүйн зөвлөгөө өгөх, түүнчлэн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шилжүүлэх, худалдах, акталж, данснаас хасах, устгах үндсэн хөрөнгийн талаар дүгнэлт, санал гаргаж холбогдох материалыг хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож, тайлагнах ажлыг тухайн хуулийн этгээдийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий хамтын удирдлагын хэлбэр мөн.

2.2. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үйл ажиллагаандаа Иргэний хуулийн холбогдох заалт, Татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан журмын хоёрдугаар хавсралтын "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ", Төрийн өмчийн хорооны 2001 оны 615 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам", НИТХ-ынТэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийнхөдөлгөөн, түүнтэй холбогдох бусадхарилцааг зохицуулах журам",болон төрийн болон орон нутгийн өмчийн талаарх бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдлөг болгоно.

2.3. Зөвлөлийг музейн захирал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн байгуулж, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд нь тусгаж, ажиллах нөхцөл боломжоор хангана.

2.4.Зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэх ба нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5. Зөвлөлийн дарга, гишүүдийг захирлын тушаалаар баталгаажуулна.

**Гурав. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн эрх, үүрэг**

3.1. Зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар тухайн жилд зохиох ажлын төлөвлөгөөг гарган байгууллагын захирлаар батлуулан мөрдөж ажиллана.

3.2. Байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг жил бүр зохион байгуулж, дутсан, буюу ашиглалтгүй байгаа, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож дүгнэлт гарган гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

3.3. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа үндсэн хөрөнгийн тоо, хэмжээ, үнийн дээд хязгаар буюу зах зээлийн үнийн судалгаа, техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж гаргаж гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

3.4. Байгууллагын эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг актлах асуудлыг судлан дүгнэлт гаргаж, байгууллагын даргын тушаалаар шийдвэрлүүлнэ.

3.5. Зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн Үндсэн хөрөнгө шинээр авах буюу актлах тухай санал хүргүүлэхээр байгууллагын гүйцэтгэх удирдлагаас шийдвэр гаргасан тохиолдолд “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийнхөдөлгөөн, түүнтэй холбогдох бусадхарилцааг зохицуулах журам”-ын дагуу холбогдох материалыг бүрдүүлж Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

3.6. Байгууллагын өмч хөрөнгийн тооллого, бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд тавих дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулж, түүнтэй холбогдох санал дүгнэлтээ бичгээр гарган гүйцэтгэх удирдлагад, түүнчлэн эрх бүхий дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

3.7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомж, журмыг мөрдөж ажиллахыг байгууллагын удирдлага болон холбогдох бусад ажилтнуудаас шаардах, тайлбар гаргуулах, үндсэн хөрөнгийн холбогдолтой асуудлыг хэлэлцэхэд оролцож санал, зөвлөмж гаргах эрхтэй.

3.8. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөс тухайн жилд зохиосон ажил, түүний үр дүн, байгууллагын өмчийн бүртгэл тооллого, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан ажлын тайланг гаргаж, жил бүрийн 12-р сарын 31-ны дотор Нийслэлийн өмч хамгаалах байнгын зөвлөлд явуулна.

**Дөрөв. Хариуцлага**

4.1. Зөвлөлийн дарга, гишүүд нь журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд байгууллагын дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.